

Модны бордоо нийлүүлэх техникийн тодорхойлолт

Зориулалт:

Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн нутагт байрлах “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа “Шижир алт” алтны үйлдвэрийн “Тэрбум мод”-ны үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022,2023 онуудад тарьсан моднуудын ургалтыг дэмжихэд ашиглагдана.

Ерөнхий шаардлага:

- 1.Захиалагчид нийлүүлэх бараа нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, заасан хэмжээнээс зөрөөгүй байна.
- 2.Бүх бараа нь олон улсын холбогдох стандарт хангасан, холбогдох мэргэжлийн байгууллагын сертификат, тодорхойлолт (дүгнэлт)-тэй байна.
- 3.Захиалагчийн тендерийн бичиг баримтад заасан барааны чанар стандартын үзүүлэлтээс давсан, илүү сайн чанар, үзүүлэлттэй байвал давуу тал болно.
- 4.Гумин, Марганц, Азаофос гэх нэр төрлийн бордоонууд нь MNS 5264:2003 стандартын шаардлагыг хангасан байх.
- 5.Шингэн хэлбэрийн, усанд уусгаж найруулж /шингэлж/ хэрэглэх зориулалттай байх.
- 6.Түгээмэл ач холбогдолтой биологийн идэвхит бодис болох натри, калийн гумат, N. K. Mg. Co. Cu. Fe зэрэг био элементүүд мөн азот шингээгч өндөр идэвхит амьд бактери, фосфор нийлэгжүүлэгч өндөр идэвхит амьд бактери, кали нийлэгжүүлэгч өндөр идэвхит амьд бактери зэргийг агуулсан байх.
- 7.Гэрээ хийгдсэнээс хойш 30 хоногийн дотор нийлүүлнэ.